



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/167

Өмнөдэлгэр сум

**Газрын дуудлага худалдааны
комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 33 дугаар тогтоолын 4, 7 дугаар хавсралтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны 05 дугаар сарын 27-ний өдөр Өмнөдэлгэр суманд явуулах газар эзэмших дуудлага худалдааны комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Бямбасүрэн

Нягтлан бодогч

Дуудлага худалдааны хөтөч: Ё.Мөнх-Өлзий

Газрын даамал

Тэмдэглэл хөтлөгч: Д.Баярхүү

Татварын улсын
байцаагч

2.Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, газар эзэмших эрх авсан иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР